



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/623

Булган сум

Согтууруулах ундаа худалдах,
түүгээр үйлчлэхийг түр хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2023-2024 оны хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс мөн оны 09 дүгээр сарын 03-ны өдрийг дуустал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн дэд хурандаа Г.Ганбаяр), сумын Засаг дарга нарт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Т.Алтанцэцэг)-нд тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

